



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2021/77-ШТА-ГА

Чойбалсан хот 2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Дэлгэрмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
Аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Гэрээт аудитор З.Шинэхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: shinekhuuz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	5
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	
А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.....	8
А.1.1 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээнүүд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019-2020 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцээгүй байна.....	9
А.1.2. Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн байна.....	9
А.1.3 Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.....	10
А.2 Төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээнүүд байна.....	10
А.2.1 ТАХ-ний зураг, төсөл, ажлын даалгавар, газрын зөвшөөрлийг жагсаалт батлуулснаас хойш боловсруулж, батлуулсан байна.....	11
А.2.2 Хугацаа хоцорсон 2 ТАХ-ний гүйцэтгэгчид хариуцлага тооцсон байна.....	12
А.2.3 Хугацаа хоцорсон 2 ТАХ-ний зураг төсөл гүйцэтгэгчид хариуцлага тооцсон байна.....	12
А.2.4 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.....	12
БҮЛЭГ 2. ГҮЙЦЭТГЭГЧИД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ДУТУУ, ЧАНАРГҮЙ, ХУГАЦАА ХЭТЭРЧ ГҮЙЦЭТГЭСЭН ЗӨРЧЛҮҮД БАЙСААР БАЙНА.....	13
Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.	13
Б.1.1. Хөрөнгө оруулалтын 2019 оны ТАХ-нүүдийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.	13
Б.1.2. Зураг, төсөл хугацаандаа батлагдаагүй шалтгаанаар 2 ТАХ тайлант хугацаанд хэрэгжээгүй байна.....	13
Б.1.3. Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.....	14
Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.	15
Б.1.5 ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.....	15
Б.2. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн зөрчлүүд гарсаар байна.....	16
Б.2.1. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн, ажил хүлээн авах комисс техникийн тодорхойлолтод бүрэн нийцээгүй автомашин хүлээн авсан зөрчлүүд илэрч байна.....	16
Б.2.2. Хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулах ажлын хэрэгжилт 80.0 хувьтай байна.....	19
Б.2.3 Гүйцэтгэгчид нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна	19
Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....	20
Б.3.1. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.....	20
Б.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд нь үндэслэн бүрэн олгосон байна.....	21
Б.3.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 2020 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.	21
Б.4. Шинээр ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, 4 ТАХ-нээс бусад нь хэвийн ажиллаж байна.....	22
Б.4.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онуудад хэрэгжсэн төсөл, арга	



хэмжээнд барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгогдоогүй байна	22
Б.4.2 Шинээр ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, 4 ТАХ-нээс бусад нь хэвийн ажиллаж байна.....	23
Холбогдох байгууллагын санал:.....	23
ДҮГНЭЛТ:	24
ЗӨВЛӨМЖ:	25
ТУШААЛ:	26
АЛБАН ШААРДЛАГА.....	28



Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
ДОА	Дорнод аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БСШУС	Боловсрол, Соёл, шинжлэх ухааны сайд
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг Дарга
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
СТ	Соёлын төв
ЭМ	Эрүүл мэнд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТОӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
ҮХ	Үнэлгээний хороо
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
СХЗХ	Стандарт хэмжил зүйн хэлтэс
ЦГ	Цагдаагийн газар
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
БТСГ	Биеийн тамир, спортын газар
ХХҮХ	Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар
ЗБОБГ	Зүүн бүсийн Онцгой байдлын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЕБС	Ерөнхий боловсролыг сургууль
ХДТ	Хөгжимт драмын театр
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ААН	Аж ахуйн нэгж



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	"ТАХ-ний төлөвлөлт"	11
Хүснэгт 2	"Улс, орон нутгийн төсвөөс 2019-2020 онд 3-аас дээш ажил авсан ААН-үүд"	15
Хүснэгт 3	"Гэрээний хугацаанаас хэтэрч хүлээлгэж өгсөн ТАХ"	16

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	"ТАХ, салбараар"	8
Дүрслэл 2	"ТАХ, нэр төрлөөр"	12
Дүрслэл 3	"Тендер зарласан хугацаа"	14



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	“Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх, 2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд санхүүжүүлсэн 67 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгадагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав. Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалын дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгадагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар, гэрээт аудитор З.Шинэхүү нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудитораар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг дарга нарт 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр хүргүүллээ.



БҮЛЭГ А. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.

А.1.1. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2019-2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцээгүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтад шинээр хэрэгжүүлэхээр нийт 62 төсөл, арга хэмжээ төлөвлөгдөн хэрэгжсэн байна.

Нийт шинээр хэрэгжсэн 62 төсөл, арга хэмжээний 14 буюу 22.6 хувь нь боловсрол, соёл урлаг, спортын салбарт, 10 буюу 16.1 хувь нь нутгийн захиргааны байгууллагад, 10 буюу 16.1 хувь нь тусгай чиг үүргийн байгууллагад, 8 буюу 12.9 хувь нь эрүүл мэндийн салбарт, 20 буюу 32.3 хувь нь бусад байгууллага, салбарт чиглэхээр төлөвлөгдсөн байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

Дүрслэл №1. “ТАХ, салбараар”



Эдгээр төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаж, батлагдсан байх шаардлагатай.

Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтад шинээр хэрэгжүүлсэн нийт 62 төсөл, арга хэмжээнээс дараах төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй байна. Үүнд:

2020 он:

1. Угтамын рашаан сувиллыг орон нутгийн өмчид шилжүүлэх /Баяндун сум, 20.0 сая төгрөг/
2. Хувилах багаж, тоног төхөөрөмж /Орон нутгийн өмчийн газар, 6.5 сая төгрөг/
3. Албан хэрэгцээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж /Санхүүгийн хяналт, аудитын алба, 9.2 сая төгрөг/
4. Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллагад шаардлагатай тоног, төхөөрөмж /Мэргэжлийн хяналтын газар, 49.0 сая төгрөг/
5. Нутгийн захиргааны 1, 2 дугаар байрны гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж /17.0 сая төгрөг/



Мөн аймгийн 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй дараах ажлууд байна. Үүнд:

2020 он:

1. Угтамын рашаан сувиллыг орон нутгийн өмчид шилжүүлэх /Баяндун сум, 20.0 сая төгрөг/
2. Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үйлдвэрлэлийн дадлагын бааз /60.0 сая төгрөг/
3. Хувилах багаж, тоног төхөөрөмж /Орон нутгийн өмчийн газар, 6.5 сая төгрөг/
4. Албан хэрэгцээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж /Санхүүгийн хяналт, аудитын алба, 9.2 сая төгрөг/
5. Нутгийн захиргааны 1, 2 дугаар байрны гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж /17.0 сая төгрөг/

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж байх нь зүйтэй байна.

А.1.2. Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3 дахь заалтын дагуу захиалагчдын саналд үндэслэсэн байх шаардлагатай.

Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 62 төсөл, арга хэмжээнээс 61 төсөл, арга хэмжээний саналыг орон нутгийн холбогдох төсөвт байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

Харин “Нисэх онгоцны буудал барих” /Баяндун, Халхгол сум/ ажлыг ИНЕГ, аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчдийн саналыг үндэслэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

А.1.3. Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвөөр 2019-2020 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” мөрдөгдөж байна.

Төсвийн тухай хууль болон уг журамд зааснаар аймгийн ТЭЗ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ орон нутгийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцон эрэмбэлсэн байх шаардлагатай.

Орон нутгийн төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн эсэхийг үзэхэд 2018.10.28-ны өдөр Дорнод их сургуулийн урлагийн зааланд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газрын дарга, Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн нар, 2019.11.14-ний өдөр аймгийн Засаг даргын тамгын газарт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн



дарга, Засаг даргын тамгын газрын дарга, Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нар болон холбогдох мэргэжилтнүүд, агентлагийн дарга нарт орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг танилцуулан, санал авч, эрэмбэлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн ч манай газраас аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн төсөлд “Нисэх онгоцны буудал барих /Баяндун, Халхгол сум/” /200.0 сая төгрөг/, Боловсрол, соёл, урлагийн газар, Статистикийн хэлтэст авто машин” худалдан авах, төсөл арга хэмжээг төсвийн тухай хуультай нийцэхгүй байна гэж үзээд төсвийн төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах саналыг оруулсан боловч төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

Мөн аймгийн төсвийн хөрөнгө оруулалтад Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн зарчимд нийцэхгүй, орон нутгийн төсөвт хамаарахгүй дараах улсын төсвийн байгууллагуудын албан хэрэгцээнд автомашин, тоног төхөөрөмж худалдан авах болон орон сууц барих ажилд төлөвлөж батлуулсан байна. Үүнд:

2019 он:

1. Монгол Улсын хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллагад автомашин /СХЗХэлтэс 30.0 сая төгрөг, МХГазар 33.0 сая төгрөг/
2. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, цэргийн алба хааж буй залуучуудад зориулсан интернет танхим байгуулах /20.0 сая төгрөг/
3. Сургалтын танхимын засвар, тохижилт, тоног төхөөрөмж, хэрэгсэл /Татварын хэлтэс 39.2 сая төгрөг/
4. Хилийн хяналтын байцаагчдын орон сууцны өргөтгөл /Баянхошуу боомт 41.0 сая төгрөг/

2020 он:

1. Төрийн байгууллагын албан хэрэгцээнд автомашин /Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 64.4 сая төгрөг/
2. Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллагад шаардлагатай тоног, төхөөрөмж /Мэргэжлийн хяналтын газар 49.0 сая төгрөг/

А.2. Төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байна.

А.2.1. ТАХ-ний зураг, төсөл, ажлын даалгавар, газрын зөвшөөрлийг жагсаалт батлуулснаас хойш боловсруулж, батлуулсан байна.

Төсөл, арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6¹, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1², 40 дүгээр зүйлийн 40.2³-т зааснаар барилга, байгууламж, түүний их засварын ажлыг гүйцэтгэхдээ зураг төсөл, ажлын даалгаврыг урьдчилан боловсруулж батлуулсан байх, газрын зөвшөөрөл, бусад техникийн нөхцөл олгогдсон байхыг тусгайлан зааж өгсөн байна.

¹ 24.6.Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.”

² 12.1. Барилгын зураг төсөл дараах шаардлагыг хангасан байна:

12.1.6. Барилгын зураг төсөл нь эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх

³ Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.



1. Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд зураг, төсөл боловсруулах шаардлагатай 669.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ байгаагаас жагсаалт батлагдсанаас хойш зураг, төсөл батлагдсан 620.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ байна.

2. Газрын зөвшөөрөл авах шаардлагатай 478.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ байгаагаас ТАХ-ний жагсаалт батлагдсанаас хойш газрын зөвшөөрөл олгогдсон 418.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ байна.

3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр 3 барилга /Хэрлэн сумын 10-р багийн байрны барилга, Матад сумын алслагдсан багийн төвийн барилга, Булган сумын орон нутгийн өмчийн орон сууц/ ашиглалтад оруулснаас 1 ТАХ-ний зургийн ажлын даалгавар хугацаа хоцорч, 2 ТАХ-нд зургийн ажлын даалгавар хийгдэлгүй зураг, төсөл боловсруулагдсан байна.

Хүснэгт №1. "ТАХ-ний төлөвлөлт"

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	ТАХ-ний жагсаалт батлагдсан огноо	Зураг төсөл батлагдсан огноо	Зургийн даалгавар батлагдсан огноо	Газрын зөвшөөрөл олгогдсон огноо
2019						
1	Хэрлэн сумын 10-р багийн байрны барилга	90.0	2018.12.05	2019.10.15	2019.04.25	2019.04.24
2	Алслагдсан багт багийн төвийн барилга барих /Матад сум/	49.0	2018.12.05	2018.11.15	Хийгдээгүй	2019.11.28
3	Орон нутгийн өмчийн орон сууцыг шинээр бий болгох /Булган сум/	79.0	2018.12.05	2019.03.06	Хийгдээгүй	2019.03.20
2020						
1	Сумын Засаг даргын Тамгын газрын нам даралтын зуухны засвар /Булган сум/	17.9	2019.12.05	2019.12.23	Шаардлагагүй	Шаардлагагүй
2	Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үйлдвэрлэлийн дадлагын бааз	60.0	2019.12.05	2019.12.23	Шаардлагагүй	2007 оны 185-р захирамж
3	Ариутгал халдваргүйтгэлийн тасгийн өргөтгөл, шинэчлэлтэд шаардлагатай цахилгаан хангамжийн ажил /бүсийн оношилгоо эмчилгээний төв	73.6	2019.12.05	2019.12.23	Шаардлагагүй	Шаардлагагүй
4	"Жуулчдад зориулсан мэдээллийн төв /Чулуунхороот сум/"	80.0	2019.12.05	2019.12.23	Шаардлагагүй	Шаардлагагүй
5	"Сумдын цагдаагийн тасаг, хэсгийн байрны засвар тохижилт /Баяндун, Дашбалбар сум/"	20.0	2019.12.05	2019.12.23	Шаардлагагүй	Шаардлагагүй
6	"Нисэх онгоцны буудал барих /Баяндун, Халхгол сум/"	200.0	2019.12.05	2019.12.23	Шаардлагагүй	Халхгол-2019.05.28 Баяндун-2020.03.17
НИЙТ		669.5		Хоцорсон-8	Шаардлагагүй - 5 Хийгдээгүй-2	Шаардлагагүй - 4 Хоцорсон-3

Хуулийн хугацаанд зураг, төслийг боловсруулж батлуулахгүй байх, жагсаалт батлагдсанаас хойш газрын зөвшөөрөл олгогдож байгаа зэрэг нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагыг хангахгүй байгаа бөгөөд тухайн төсөл, арга



хэмжээний худалдан авах ажиллагаа оройтож зарлагдах, улмаар тайлант хугацаанд хэрэгжихгүй байх зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

А.2.2. Хугацаа хоцорсон 2 ТАХ-ний зураг төсөл гүйцэтгэгчид хариуцлага тооцсон байна.

Орон нутгийн 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд нийт 5 ТАХ-нд 11,115.7 мянган төгрөгийг зураг, төслийн санхүүжилтэд олгохоос 10,163.7 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна. Үүнээс:

- Алслагдсан багт багийн төвийн барилга барих /Матад сум/-ын зураг, төсөлд 3500.0 мянган төгрөг олгохоос 2555.0 сая төгрөгийг олгосон нь 135 хоногийн алданги тооцсонтой холбоотой байна.
- Хилийн хяналтын байцаагчдын орон сууцны өргөтгөл /Баянхошуу боомт/-ын зураг, төсөлд 500.0 мянган төгрөг олгохоос 493.0 мянган төгрөгийг олгосон нь 14 хоногийн алданги тооцсонтой холбоотой байна.

2020 оны төсөл, арга хэмжээний хувьд зураг, төсөл зохиогчийн гүйцэтгэлд үндэслэж, 5480.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоос 100.0 хувь олгосон байна.

А.2.3. Орон нутагт зураг төсвийн магадлалаар баталгаажуулах барилгын ажил байхгүй байна.

ЗГ-ын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах, магадлал хийх дүрэм”-д зааснаар 2019-2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд барилгын 1-р төвөгшилд хамаарах 2 барилгын ажил байгаа бөгөөд эдгээр нь зураг, төсвийн магадлал хийлгэх шаардлагагүй ажлууд байна.

А.2.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжсэн нийт 2.5 тэрбум төгрөгийн 62 төсөл, арга хэмжээний 12.9 хувийг барилга байгууламж, 29.0 хувийг их засварын ажилд, 58.1 хувийг машин, тоног төхөөрөмж худалдан авах ажилд тус тус зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

Дүрслэл №2. “ТАХ, нэр төрлөөр”





Дээрх төсөл, арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын шинж чанартай бус “Шинээр ашиглалтад орж буй хүүхдийн цэцэрлэгт зөөлөн эдлэл худалдан авах /Хэрлэн сумын 17, 18-р цэцэрлэг/ 10.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээг 2019 онд төлөвлөж батлуулсан байна.

Б. ГҮЙЦЭТГЭГЧИД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ДУТУУ, ЧАНАРГҮЙ, ХУГАЦАА ХЭТЭРЧ ГҮЙЦЭТГЭСЭН ЗӨРЧЛҮҮД БАЙСААР БАЙНА.

Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Б.1.1. Хөрөнгө оруулалтын 2019 оны ТАХ-нүүдийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.

Дорнод аймгийн Засаг дарга 2019 онд 9 төсөл, арга хэмжээ, 2020 онд 7 төсөл, арга хэмжээний эрхийг холбогдох сум, төсвийн байгууллагуудад шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор шилжүүлэх журмын заалттай.

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020.01.02-ны өдрийн А/10 дугаар захирамжаар эрх шилжүүлсэн нь дээрх журамтай нийцэж байна.

Харин 2019 онд шинээр хэрэгжүүлэх 9 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2019.02.11-ний өдрийн А/74 дүгээр захирамжаар эрх шилжүүлсэн нь хуулийн хугацаанаас 8 хоногоор хоцроож журмын 2.13 дахь заалтыг зөрчсөн байна.

Б.1.2. Зураг, төсөл хугацаандаа батлагдаагүй шалтгаанаар 2 ТАХ тайлант хугацаанд хэрэгжээгүй байна.


Худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөнд тусгасан хугацаанаас 8-203 хоногоор хойшилж тендер зарлагдсан 27 ТАХ, 2020 оны төлөвлөгөөнд тусгасан хугацаанаас 14-130 хоногоор хойшилж, тендер зарлагдсан 23 ТАХ-нүүд байна. (2019-2020 оны тендер зарлахаар төлөвлөсөн хугацаа, зарласан хугацааны харьцуулсан хүснэгтийг хавсралт №1-ээр харуулав.)

2019 оны төсөл, арга хэмжээнүүдийн хувьд тендер нь төлөвлөгөөнд заасан хугацаанаас оройтож зарлагдсан ч тайлант хугацаанд хэрэгжиж дууссан байна.

2020 оны төсөл, арга хэмжээнүүдийн хувьд 21 нь тайлант хугацаандаа хэрэгжиж, 2 ТАХ тайлант хугацаанд хэрэгжээгүй байна. Зураг, төсөл хугацаандаа батлагдаагүйгээс “Төрийн албан хаагчдын орон сууцыг шинээр бий болгоход дэмжлэг” /Гурванзагал сум/, “Чингис хааны хар сүлдний тахилгын байгууламжийг барих ажлыг эхлүүлэх” /Булган сум/ ажлын тендер зохион байгуулагдсан ч оролцогч байхгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.



Дүрслэл №3. “Тендер зарласан хугацаа”



Тендерийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс хоцорч зарлаж байгаа шалтгаан нь төсөл, арга хэмжээний зураг, төслийг хугацаанд нь боловсруулж батлуулаагүй, зураг төсөлгүй ТАХ батлагдсантай холбоотой байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэж заасан бөгөөд уг заалтаар үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ, ЗДТГ-ын төлөөллийг оролцуулна гэсний дагуу оролцуулсан байна.

Үнэлгээний хороодын 2020 онд зохион байгуулсан зарим худалдан авах ажиллагаагаар тендерийн баримт бичигт тусгасан шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна. Тухайлбал:

1. “Нисэх онгоцны буудал барих” /Баяндун, Халхгол сум/-ын ажлын тендерт оролцсон Стандарт рэзидэнс констракшин ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТООЗ-ын 5.3.(ө)⁴, 14.1(ж)⁵-д заасан шаардлагыг хангаагүй байхад;
2. “Сумын Засаг даргын Тамгын газрын нам даралтын зуухны засвар” /Булган сум/-ын ажлын тендерт оролцсон Элтрүүд ХХК нь ажил гүйцэтгэх төсвийн захиалагчийн албаны зардал, зураг төсөв зохиогчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлын дүн нь энэ ажлын батлагдсан төсөвт тусгасан тухайн зардлын дүнтэй зөрүүтэй байхад;
3. “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасагт автомашин” нийлүүлэх тендерт оролцсон Дорнын этүгэн ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТООЗ-ын 1.1.⁶-д заасан шаардлагыг хангаагүй байхад;
4. “Сумдын цагдаагийн тасаг, хэсгийн байрны засвар, тохижилт”-ын ажлын тендерт оролцсон Дорнын их дөл ХХК-ийн тендерийн материалд барилгын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ байхгүй, ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ерөнхий болон барилгын инженерийн мэдээллийг ирүүлээгүй байхад;
5. “Жуулчдад зориулсан мэдээллийн төв” /Чулуунхороот сум/-ийн ажлын тендерт оролцсон Донж Өргөө ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТООЗ-ын 1.1.⁷-д заасан шаардлагыг хангаагүй байхад;

⁴ ... Түрээсээр ашиглах бол техникийн хэрэгслийн түрээсийн гэрээг ирүүлэх бөгөөд түрээсийн гэрээг тухайн төсөлд зориулан байгуулсан байна.

⁵ 9. Тендерт оролцогч нь өөр барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа бол энэ тухай мэдээллийг ирүүлэх шаардлагатай бөгөөд зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд ..., машин механизмуудыг санал болгох ба давхацсан тохиолдолд татгалзах үндэслэл болно. 11. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын дагуу барилгын засварын ажилд ашиглах Монгол Улсын гарал үүсэлтэй бараа, материалын жагсаалт, хэмжээг хүснэгтийн дагуу гаргаж ирүүлэх.

⁶ ... Шүүхийн байгууллагын тодорхойлолт, ... Сүүлийн 2 жил гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээ, хүлээлгэн өгсөн комиссын актыг хавсаргана.



6. “Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үйлдвэрлэлийн бааз”-ын ажлын тендерт оролцсон Дорнод хийц ХХК-ийн тендерийн материалд барилгын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралт байхгүй байхад.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-д “Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна:”, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 5.2-т “Үнэлгээний хороо хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дараах журам, зааврыг мөрдөж ажиллана”, 5.2.4⁸-д заасантай нийцэхгүй байна.

Цаашид үнэлгээний хороод нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тухайн төсөл, арга хэмжээнээс хамааруулан холбогдох шаардлагыг оновчтой тусгаж, шаардлага хангасан оролцогчийг сонгон шалгаруулах нь зүйтэй байна.

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2019-2020 онд шинээр хэрэгжсэн 62 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим болон уламжлалт хэлбэрээр зохион байгуулснаас 2019 онд цахимаар 31, уламжлалтаар 1, 2020 онд цахимаар 26, уламжлалтаар 4 байна.

Хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс 3-аас дээш тооны хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэхээр шалгарсан зарим компаниудын ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №2. “Улс, орон нутгийн төсвөөс 2019-2020 онд 3-аас дээш ажил авсан ААН-үүд”

№	Аж ахуйн нэгжийн нэр	2019 он			2020 он		
		Улсын төсөв /ТАХ-ний тоо/	Орон нутгийн төсөв, ОНХС /ТАХ-ний тоо/	НИЙТ ТАХ тоо	Улсын төсөв /ТАХ-ний тоо/	Орон нутгийн төсөв, ОНХС /ТАХ-ний тоо/	НИЙТ ТАХ тоо
1	Бүжнар ХХК	2	2	4	1	3	4
2	Донж өргөө ХХК	3	1	4	2	2	4
3	Ган октаэдр ХХК	2	3	5	1	7	8
4	Дорнод хийц ХХК	1	2	3	1	8	9

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний хувьд дээрх компаниудын гүйцэтгэсэн ажлын чанарт асуудал гараагүй байна.

⁷ Түрээсийн гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх ... бусад асуудлыг тодорхой тусгасан байна.

⁸ Тендерийг үнэлэхэд холбогдох хууль болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан заавар, аргачлал, захиалагчийн боловсруулсан тухайн тендерийн баримт бичгийг баримтлах.

**Б.1.5. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.**

ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, тайлагнасан эсэхийг үзэхэд орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 49.5-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Б.2.1. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн, ажил хүлээн авах комисс техникийн тодорхойлолтод бүрэн нийцээгүй автомашин хүлээн авсан зэрэг зөрчлүүд байна.

Барилгын тухай хуулийн 40.2 болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэгч нь зураг, төслийн дагуу ажил, үйлчилгээг хугацаанд нь буюу чанартай гүйцэтгэхээр заасан байна. Харин гэрээний хугацаа, чанартай холбоотой дараах зөрчлүүд илэрч байна.

Гэрээ дуусах хугацаанаас хоцроож хүлээлгэж өгсөн дараах ажлууд байна.

Хүснэгт №3. “Гэрээний хугацаанаас хэтэрч хүлээлгэж өгсөн ТАХ”

№	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээний дүн /сая.төг/	Хэтэрсэн хоног /актын огноо/	Гүйцэтгэгч компани	Тайлбар, шалтгаан
1	Соёлын төвийн халаалтын тогоо шинэчлэх ажил /Булган сум/	8.0	4	“Элтрүүд” ХХК	Алданги тооцсон байна.199393
2	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасагт авто машин	17.8	4	“Дорнын этүгэн” ХХК	Алданги тооцсон байна. 235600
3	Хүүхдийн тасагт УВЧ аппарат худалдан авах /Бүсийн оношилгоо, эмчилгээний төв/	5.4	41	“Мед буян” ХХК	Алданги тооцсон байна. 540000

Гэрээний хугацаанаас 4-41 хоногоор хугацаа хоцорсон 3 ТАХ-нд нийт 974,993.0 төгрөгийн алданги тооцсон байна.

Аудитын явцад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэхэд гүйцэтгэл дутуу, чанаргүй хийгдсэн дараах ажлууд байна. Үүнд:

2019 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт:

1. ТАХ-ний нэр: "Угтам" рашаан, сувиллын гадна хашаа барих /Баяндун сум/
Төсөвт өртөг: 10.0 сая төгрөг
Гүйцэтгэгч: МСҮТ





Хэрэгжилт: Хашааны хэмжээ нь 1,2м х 2,0м хэмжээтэй, 80 ширхэг байхаар ажлын тоо хэмжээнд тусгагдсан боловч хийгдсэн хашаа нь 0,75м х 2,0м хэмжээтэй 96 ширхэг хашаа хийгдсэн нь 48 м² хашаа дутуу хийгдсэн нь зураг, төслийн дагуу хийгдээгүй байна.

2. **ТАХ-ний нэр:** Хилийн хяналтын байцаагчдын орон сууцны өргөтгөл /Баянхошуу боомт/
Төсөвт өртөг: 41.0 сая төгрөг
Гүйцэтгэгч: “Дорнын их өгөөж” ХХК



Хэрэгжилт: Өргөтгөлийн барилгын ажил чанаргүй хийгдэж, дээвэр, цонх, хана, таазны хэсэгт эвдрэл, гэмтэл гарсныг гүйцэтгэгч компаниар дахин засварлуулсан боловч одоог хүртэл ашиглалтын шаардлага хангахгүй байна.

3. **ТАХ-ний нэр:** Халуун усны барилгын засварт дэмжлэг /Чулуунхороот сум/
Төсөвт өртөг: 70.0 сая төгрөг
Гүйцэтгэгч: “Тэгш титан” ХХК



Хэрэгжилт: Барилгын ашиглалтын явцад эвдрэл гэмтэл үүсэж, дээвэр, хана, цонх, гадна фасад, дотор засал ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь чанаргүй хийгдсэнтэй холбоотой байна. Энэ талаар аймгийн МХГ-ын улсын байцаагчаас ашиглагч байгууллагад зөвлөмж өгөгдсөн байна.

4. **ТАХ-ний нэр:** Сумын сургуулийн хуучин дотуур байрыг орон нутгийн өмчийн орон сууц болгон засварлах /Чойбалсан сум/
Төсөвт өртөг: 70.0 сая төгрөг
Гүйцэтгэгч: “ИГ” ХХК





Хэрэгжилт: Барилгын засварын ажил чанаргүй хийгдэж, коридорын өрөөний дулааны шугам хагарсан байдалтай, шал, хананы заслын ажил ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь чанаргүй хийгдсэн тэй холбоотой байна. Ашиглагч байгууллагаас гүйцэтгэгч байгууллагад хүсэлт тавьсан боловч одоог хүртэл дахин засварлаагүй байна.

5. **ТАХ-ний нэр:** Орон нутгийн өмчийн орон сууцыг шинээр бий болгох /Булган сум/
Төсөвт өртөг: 79.0 сая төгрөг
Гүйцэтгэгч: “ИГ” ХХК



Хэрэгжилт: Өрөөнүүдийн тааз, дээврийн дулаалга чанаргүй хийгдсэнээс шалтгаалж 1 орон сууцны зочны өрөөний дээврээс салхи нэвтэрч, лампирэн тааз доош унасан байдалтай, үүдний өрөөний /тамбур/ хана, таазны доторлогоо хангалтгүй, зай завсартай байгаа нь чанаргүй хийгдсэнийг харуулж байна.

6. **ТАХ нэр:** Аймгийн БТСГ-ын хэрэгцээнд автомашин авах
Төсөвт өртөг: 40.0 сая төгрөг
Гүйцэтгэгч: “Мөнх орших баян” ХХК

Хэрэгжилт: Аймгийн БТСГ-т нийлүүлэгдсэн Hyundai County маркийн дунд оврын автобус нь техникийн тодорхойлолтод 25 хүний суудалтай, спидометр 150,000 км-ээс ихгүй гүйлттэй, 2018 оноос хойш импортлогдсон байх зэрэг шаардлагыг хангасан байхаар заасан байна. Гэтэл техникийн тодорхойлолтыг автомашинд нийцүүлэн дахин боловсруулж, комиссын гишүүдийн 2/5 нь тухайн автобусыг техникийн тодорхойлолтод бүрэн нийцэхгүй байна /өнгө үзэмж, зориулалт/ гэсэн саналыг гаргаж байсан боловч олонхын саналаар хүлээн авсан байна.



2020 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт:

1. **ТАХ-ний нэр:** Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын өргөтгөл, нэг цэгийн үйлчилгээний төв /Чулуунхороот сум/
Төсөвт өртөг: 83.3 сая төгрөг
Гүйцэтгэгч: “Тэргүүн констракшн” ХХК



Хэрэгжилт: Өргөтгөлийн барилгын дээврээс борооны ус дууссан, хананд цууралт үүссэн, хаалганы хүрээ салсан байдалтай байгаа нь чанаргүй хийгдсэнийг харуулж байна.

2. **ТАХ-ний нэр:** Сумын Засаг даргын Тамгын газарт авто машин /Гурванзагал сум/

Төсөвт өртөг: 45.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: “Батбилэг Гурван Эрдэнэ” ХХК

Хэрэгжилт: Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газарт нийлүүлэгдсэн Land Cruiser-100 маркийн авто машин нь техникийн тодорхойлолтод спидометрийн гүйлт 80,000 км-ээс ихгүй, 2012 оноос хойш импортоор оруулж ирсэн байх зэрэг шаардлагыг тавьсан байна. Гэтэл хүлээж авах үед спидометрийн заалтыг хүлээлцээгүй, 2021 оны 05 дугаар сарын байдлаар 120,000 км гүйлттэй байгаа нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагад бүрэн нийцэхгүй байна.

Дээрх барилга, байгууламж, засварын ажлууд ашиглах явцад асуудал үүсэж байгаа нь гүйцэтгэгч байгууллагын чанаргүй ажил гүйцэтгэсэнтэй холбоотой бөгөөд дахин засаж залруулах, дахин засварлах ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн байгууллагуудад хариуцлага тооцох шаардлага үүссэн байна.

Мөн техникийн тодорхойлолтод бүрэн нийцээгүй автомашин нийлүүлэгдэж байгаа нь тендерийн үнэлгээ, хүлээж авах комиссын үйл ажиллагаатай холбоотой бөгөөд цаашид энэ талаар алдаа, зөрчил гаргахгүй байхад анхаарах шаардлагатай байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2019-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



Төрийн байгууллагын 2 барилга /Хэрлэн сумын 10-р багийн барилга, Матад сумын багийн байр/



Орон нутгийн өмчийн 3 барилга /Булган, Чойбалсан сум орон сууц, Чулуунхороот сумын халуун усны барилга/



Барилгын өргөтгөл, бааз, төв байгуулах 5 газар /Халхгол сум Баянхошуу боомт МХГ-ын ажилчдын байр, Хэрлэн сум МСҮТ-ын бааз, Чулуунхороот ЗДТГ, боомт, Баян-Уул сум ахмадын байр/



7 Торон сууцны дээврийн засвар /Хэрлэн, Халхгол сум/



3 Цагдаагийн хэсгийн засвар, тохижилт /Хэрлэн сумын 2-р баг, Дашбалбар, Баяндун сум/



19 газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Хэрлэн сум БОЭТ-ийн хүүхдийн тасаг, нөхөн сэргээх тасаг, Нийгмийн ЭМТ-д 2 удаа, ОНӨГ-т 2 удаа, МХГ-т 2 удаа, ГХБХБГ, ЗБОБГ, БТСГ, ХДТ, 17, 18-р цэцэрлэг, ХДТ, 4, 9, 17 дугаар цэцэрлэг, СХАА, Нутгийн захиргааны байгууллага, Багшийн хөгжил төв, Булган сумын СТ, авто зам, Хэрлэн сумын соёл урлагийн салбар г.м/



Танхим, төв байгуулах 2 газарт /Дайчилгаа, Багш хөгжлийн төв/



13 газрын засвар, тохижилт /Татварын хэлтэс, УБХ-ийн нэг цэг, Баяндун Угтам, Хэрлэн сумын 5-р цэцэрлэг, ХДТ-ын ариун цэврийн өрөө, Г.К.Жуковын музейн дотор, гадна, БОЭТ-ын дотор, ариутгал халдваргүйтгэлийн тасаг, цахилгаан шат, Халхгол сум Буйр сургалтын бааз, Баян-Уул сум гал унтаах төв, Хэрлэн сумын Бэлтгэл үүрэгтний сургалтын төв г.м/



2 газарт нисэх онгоцны буудал /Халхгол, Баяндун сум/



5 газрын халаалтын тогооны засвар /Хөлөнбуйр ЗДТГ, Булган ЗДТГ, СТ, Баяндун ЕБС, Чойбалсан ЭМТ



23 автомашин /Аймгийн ЗДТГ, ЦГ-3, БТСГ, Төрийн аудит, СХЗХ, МХГ-2, БОАЖГ, Татварын хэлтэс, ХХҮХ, ОБГ, Орон нутгийн өмчид 2, Мал хулгайлах тасаг, Цагаан-Овоо ЗДТГ, Баян-Уул ЗДТГ, Гурванзагал ЗДТГ, Баян-Уул, Хөлөнбуйр, Сэргэлэн, Чойбалсан сумдын цагдаагийн хэсэг/

Б.2.2. Хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулах ажлын хэрэгжилт 80.0 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.11-д заасны дагуу захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

Орон нутгийн 2019-2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 62, өмнөх оноос шилжиж ирсэн 5 нийт 67 ТАХ байгаагаас бүгд хэрэгжиж дууссан бөгөөд 32 ТАХ нь тоног төхөөрөмж байна.

Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг авч үзэхэд 5 ажлыг үүрэг даалгавар өгч хүлээн авсан байна.

Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй дараах ажил байна. Үүнд:

- Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үйлдвэрлэлийн дадлагын бааз ажлыг “Дорнод хийц” ХХК гүйцэтгэж 2020.12.20-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. “Ковид-19” цар тахлаас шалтгаалан зөөврийн сууцыг газрын тосны 21 дүгээр талбайд байрлуулах, бохир, цэвэр ус, цахилгааныг гадна шугам сүлжээнд холбох ажлыг дулааны улиралд гүйцэтгүүлэхээр үүрэг даалгавар өгсөн байна.

Б.2.3. Гүйцэтгэгчид нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэгчид шилжүүлэх санхүүжилтээс гадна тухайн ажлын гэрээний үнийн дүнд багтсан захиалагчийн албаны зардлыг ГХБХБГ-т, зураг төсөл зохиогчийн болон хяналтын зардлыг зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгжид тус тус шилжүүлдэг байна.



ТАХ-ний гүйцэтгэгчид нь өөрийн болон банкнаас авсан зээлийн хөрөнгөөр тухайн ажлыг гүйцэтгэх явцад, эсхүл дууссан үед тодорхой ажлын гүйцэтгэлийг гарган холбогдох үе шатны хяналтаар орсны дараа санхүүжилтийг олгох тухай албан бичгийг захиалагчид хүргүүлсэн байна.

Захиалагч ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо тухайн ажлын гүйцэтгэлийн баримт, захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт материал, ажлыг хүлээн авсан комиссын дүгнэлт зэргийг үндэслэж олгосон байна. Аудитын явцад тайлант онд хэрэгжсэн ТАХ-ний ажлын гүйцэтгэл, түүний зураг төсөл зохиогч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт болон холбогдох бусад баримт материалаас үзэхэд ТАХ-ний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон гэдгийг харуулж байна.

Мөн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчдийн арилжааны банкин дахь дансны хуулгаас үзэхэд гүйцэтгэгчид нь тухайн төсөл, арга хэмжээнд зориулж зардлыг гаргасан байна. Эдгээрээс үзэхэд гүйцэтгэгчид нь тухайн ТАХ-ний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.3.1. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Захиалагч болон зохиогчийн хяналт нь Барилгын тухай хуулийн 35, 37, 38.1.8, “Барилгын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн 2.2, 3.1.4, 3.4, 3.6, 3.12, 3.14 дэх заалтууд, холбогдох яам, агентлаг, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжиж байна.

Зохиогчийн хяналтын зардлыг зураг, төсөв зохиогч хувь хүн, аж ахуйн нэгжид олгосон бол захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБГ-т олгосон нийт 18.7 сая төгрөгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт төвлөрүүлж ажилласан байна.

Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ГХБХБГ-аас хяналтын ажлын тайлан, холбогдох материалыг авч гүйцэтгэлийг гүйцэтгэгч болон ашиглагч байгууллагатай хийсэн ярилцлага, ажлын зураг, бодит нөхцөл байдалтай тулган үзсэн.

Захиалагч нь зураг төсөл зохиогч нартай Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн, 38.1.8 дахь заалтын дагуу зохиогчийн хяналтын гэрээ байгуулан үе шатны ажилбар бүрд хяналтыг хамтран хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус газраас хэрэгжүүлсэн захиалагчийн хяналтын ажлын үр дүнг хангалттай гэж үнэлсэн бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд гарч байгаа зөрчил дутагдал нь гүйцэтгэгч компаниас ихээхэн шалтгаалж байна.

Б.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд нь үндэслэн бүрэн олгосон байна.

Аймгийн ЗДТГ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох ёстой.



Аудитын хамрах хүрээнд 2019-2020 онд хэрэгжсэн 67 төсөл арга хэмжээний санхүүжилт хугацаандаа олгогдож, ажил нь хийгдсэн байна.

Дээрх журмын дагуу төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 2019-2020 онд бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэхийг ярилцлагаар болон баримт материалтай тулган баталгаажуулахад журмын заалтын дагуу хэрэгжүүлсэн байна.

Б.3.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 2020 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.

ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.” Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн эрсдэлийг бага гэж тооцсон тул дотоод хяналтыг хийгээгүй байна.

Тус алба нь 2018, 2019 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 3 дугаар саруудад дотоод хяналтыг хийсэн ч тайлан эцэслэн дуусаагүй хяналтын шатанд явагдаж байна.

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд дотоод хяналт шалгалтыг 2021 оны 9, 10 дугаар сард хийхээр төлөвлөгөө, удирдамжид оруулж ТЕЗ-аар батлуулсан байна.

Сүүлийн 3 жилд хийсэн манай аудитаас харахад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж байгаа хяналт нь цаг хугацааны хувьд оновчтой бус байгаагаас үр дүнд нөлөөлж байна.

Иймд аймгийн Засаг дарга дотоод аудитын төлөвлөгөөг батлахдаа хууль, журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор цаг хугацааг зөв хуваарилж батлах шаардлагатай байна.

Б.4.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онуудад хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгогдоогүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онуудад хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгогдоогүй байна.

Б.4.2. Шинээр ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, 4 ТАХ-нээс бусад нь хэвийн ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд шинээр ашиглалтад орсон 10 барилга, байгууламж, 42 байгууллагад нийлүүлсэн тоног төхөөрөмжийг төсөвт байгууллагуудын эзэмшилд шилжүүлж, бүртгэл, тайланд тусган ашиглаж байна.

Хэрлэн сумын 10 дугаар баг, Матад сумын алслагдсан суманд багийн төвийн барилга, Баян-Уул суманд ахмадын байрны өргөтгөл, Чулуунхороот халуун усны газар, Булган, Чойбалсан сумдад орон нутгийн өмчийн орон сууцыг бий болгосноор төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хурдан шуурхай хүргэх, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн байна.

Чулуунхороот сумын Засаг даргын Тамгын газрын барилгын өргөтгөл, нэг цэгийн үйлчилгээний төв, Жуулчдад зориулсан мэдээллийн төвийг ашиглаж эхлээгүй нь "Ковид-19" цар тахлаас шалтгаалан доторх тохижилтын ажил хийгдээгүй байна.

Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үйлдвэрлэлийн дадлагын бааз ажиллаж эхлээгүй шалтгаан нь "Ковид-19" цар тахлаас шалтгаалан зөөврийн сууцыг газрын тосны 21 дүгээр талбайд байрлуулах, бохир, цэвэр ус, цахилгааныг гадна шугам сүлжээнд холбох ажлыг дулааны улиралд гүйцэтгүүлэх, мөн оюутны дадлагын ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Нисэх онгоцны буудал барих /Баяндун, Халхгол сум/ ажил дууссан ч ашиглаж эхлээгүй байна. Энэ нь зураг төсвийн дагуу агаарын хөлөг хөөрч, буух зурвас газрыг байгуулах, хашаажуулах ажил хийгдсэн ч хамгаалалтын зурвас, тэмдэг, тэмдэглэгээ, бусад нөхцөлүүд бүрэн бүрдээгүйтэй холбоотой байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


 МОНГОЛ УЛС
 ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
 21000, Чойбалсан, Дорнод аймг
 Утас: 7038-4202, факс: 7038-4584
 2021.05.27 № 7/290
 тавигч 2021.05.24 № 111

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
 АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
 ТАНАА

"Орон нутгийн төсвийн 2019-2020 оны
 хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр
 дүн, үр ашиг"-т хийсэн аудитын тайлангаар
 ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА  М.БАДАМСҮРЭН
 2021.05.27
 010521345



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын 62 төсөл, арга хэмжээнүүд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019-2020 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцээгүй байна.
2. Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчдын саналд үндэслэгдсэн байна.
3. Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.
4. ТАХ-ний зураг, төсөл, ажлын даалгавар, газрын зөвшөөрлийг жагсаалт батлуулснаас хойш боловсруулж, батлуулсан байна.
5. Хугацаа хоцорсон 2 ТАХ-ний зураг төсөл гүйцэтгэгчид хариуцлага тооцсон байна.
6. Орон нутагт зураг төсвийн магадлалаар баталгаажуулах барилгын ажил байхгүй байна.
7. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.
8. Хөрөнгө оруулалтын 2019 оны ТАХ-нүүдийг хугацаа хоцроож эрх шилжүүлсэн байна.
9. Зураг, төсөл хугацаандаа батлагдаагүй шалтгаанаар 2 ТАХ тайлант хугацаанд хэрэгжээгүй байна.
10. Төндөрийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.
11. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.
12. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.
13. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн, ажил хүлээн авах комисс техникийн тодорхойлолтод бүрэн нийцээгүй автомашин хүлээн авсан зөрчлүүд илэрч байна.
14. Хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулах ажлын хэрэгжилт 80.0 хувьтай байна.
15. Гүйцэтгэгчид нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
16. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хэрэгжүүлсэн байна.
17. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд нь үндэслэн бүрэн олгосон байна.
18. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 2020 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.
19. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онуудад хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгогдоогүй байна.
20. Шинээр ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, 4 ТАХ-нээс бусад нь хэвийн ажиллаж байна.



Аудитаар нийт 1,967.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,967.8 сая төгрөгийн зөрчил арилгах 6 албан шаардлага, 3 зөвлөмж өглөө.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд зөвлөж байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.
2. ХАА-г зохион байгуулахдаа төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг баримталж, тендерийн баримт бичгийн иж бүрэн байдлыг хангаж ажиллах.
3. Ашиглалтгүй байгаа төсөл, арга хэмжээг цаашид ашиглалтад оруулах талаар холбогдох байгууллагуудад хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллах, хөрөнгийн үр өгөөжийг сайжруулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 08

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга М.Энхтөр, Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.




Б.БОЛОРТУУЛ

011012039



Тэргүүлэх аудиторын 2021 оны 05 дугаар
сарын 17-ны өдрийн 08 тоот тушаалын хавсралт



Албан шаардлагын жагсаалт

2021.05.27.

№	Байгууллагын нэр	Аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/77-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	491.0
2	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/77-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-
3	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/77-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	353.3
4	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/77-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	85.0
5	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/77-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	1038.5
6	Аймгийн ЗДТГ	ДОА-2021/77-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-
Нийт дүн				1,967.8



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 05 сарын 27-н өдөр
Дотоод аудит / 2021-05-27-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд МҮЕА-ын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд зураг, төсөл боловсруулах шаардлагатай 669.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ байгаагаас жагсаалт батлагдсанаас хойш зураг, төсөл батлагдсан 620.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ.
- Газрын зөвшөөрөл авах шаардлагатай 478.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ байгаагаас ТАХ-ний жагсаалт батлагдсанаас хойш газрын зөвшөөрөл олгогдсон 418.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр 3 барилга /Хэрлэн сумын 10-р багийн байрны барилга, Матад сумын алслагдсан биеийн төвийн барилга, Булан сумын орон нутгийн өмчийн орон сууц/ ашиглалтад оруулснаас 1 ТАХ-ний зургийн ажлын даалгавар хугацаа хоёрч, 2 ТАХ-нд зургийн ажлын даалгавар хийгдэлгүй зураг, төсөл боловсруулагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь "Төсөл захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үрсэл болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбоходоо норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэн", 29 дүгээр зүйлийн 29.4 дэх "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийхдээ зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тулгарна" Барилгын тухай хуулийн 12.1.1 дэх "Барилгын зураг төсөл нь эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх", 40 дүгээр зүйлийн 40.2 дахь "Барилгын ажлын зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

011041259

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгз биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даатан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.8-4.2.1.9, 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Холбогдох хууль, журамд заасны дагуу зураг, төсөл, зургийн ажлын даалгавар нь батлагдсан, газрын зөвшөөрөл болон бусад техникийн нөхцөл олгогдсон төсөл, арга хэмжээг төлөвлөж байх.
- Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
АУДИТОР Я.ЗОРИГ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 05 сарын 27-н өдөр
Дотоод аудит / 2021-05-27-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд МҮЕА-ын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Утгам рашаан, сувиллын гадна хашаа барих /Баяндун сум/" ажил нь зураг, төсөл дэх тоо хэмжээнд хүрээгүй, 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Халуун усны барилгын засвар дэмжлэг /Чулуунхороот сум/", 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын сургуулийн хуучин дотуур байрыг орон нутгийн өмчийн орон сууц болгон засварлах /Чойбалсан сум/", 79.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Орон нутгийн өмчийн орон сууцыг шинээр бий болгох /Булан сум/", 41.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хилийн хяналтын байцаагчдын орон сууцны өргөтгөл /Баянхошуу боомт/", 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 83.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын өргөтгөл, нэг цэгийн үйлчилгээний төв /Чулуунхороот сум/" зэрэг төсөл, арга хэмжээнүүд нь чанаргүй, дутуу хийгдсэний улмаас ашиглалтын шаардлага хангахгүй байна.

Энэ нь ТБОНХБХАУХАТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх "Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцоходоо гэрээний үүрэгз ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэрэгжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, энэ хуулийн 52¹-д заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон", 52¹ дүгээр зүйлийн 52¹-д хуудсанд авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт төлөх эрх бүхий улсын ахлах байцаагч, улсын байцаагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагчид төв байгууллагад байх", Засгийн газрын 2018 оны 317 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 4.7 дахь "Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутаагдлыг 14 хоногт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ", Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.14 дэх "Барилгын ажлыг барилга байгууламжийн зурга төсөл, норм, нормативын баримт бичиг болон техникийн нөхцөлийг зөрчиж чанаргүй, эсхүл дутуу гүйцэтгэсэн нь барилга

011041262

байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлт, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоосон тохиолдолд захиалагч барилгын ажлыг түр зогсоож, тухайн зөрчил дутаагдлыг гүйцэтгэгчийн зордлаар засуулах, дутуу ажлыг гүйцэтгэж хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг арга хэмжээг өгнө. Гүйцэтгэгч зөрчлийг арилгаагүй тохиолдолд барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгз биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даатан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.8, 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Барилга, байгууламж, их засварын ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэсэн МСҮТ, "Тэгш титан" ХХК, "ИГ" ХХК, "Тэргүүн констракшн" ХХК, "Дорнын их өгөөж" ХХК-иудад хугацаатай үүрэг даалгавар өгч, дахин засварлуулах.
- Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 30-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
АУДИТОР Я.ЗОРИГ




ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 05 сарын 27 өдөр
Дугуйр 389/116041263-2021/77-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн 2019 оны хөрөнгө оруулалтаар аймгийн Бишгийн тамир, спортын газарт "Мөнх орших баян" ХХК-иас 40.0 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн Hyundai County маркийн дунд оврын автобус нь техникийн тодорхойлолтод бүрэн нийцэхгүй (Комиссын гишүүдийн 2/5 нь тухайн автобус нь техникийн тодорхойлолтод бүрэн нийцэхгүй байна гэж үзсэн. Үүнд: Өнөө үзэмж, зориулалт хамаарна), 2020 оны хөрөнгө оруулалтаар Гурванзагал сумын ЗДТТ-т "Батбилэг Гурван Эрдэнэ" ХХК-иас 45.0 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн Land Cruiser-100 маркийн автомашин нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй (Техникийн тодорхойлолтод спидометрийн үйлт 80,000 км-ээс ихгүй байх гэж заасан боловч хүлэж авах үед спидометрийн заалтыг хүлэцгээж, 2021 оны 05 дугаар сарын байдлаар 120,000 км гүйлгээтэй байна) байна.

Энэ нь ТБОНХБАХАТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх "Тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмжээтэй, эдийн засгийн үр ашгатай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь бодогд орчин, хүний зэрүү мэдээд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал бага бай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох", 27 дугаар зүйлийн 27.1.1 "Төндөр нээсний дараа төндөр тус бүр нь дараах шаардлагаа хангасан эсэхийг хянан үзнэ. Техникийн тодорхойлолт", 27.3 дахь "Төндөр нь энэ хуулийн 27.1.3 заасан бүрэнхүлээний нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн төндөр гэж үзнэ", Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаал "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 11.4 дэх "Залуучаан хурдан асан тоног төхөөрөмжийг комисс байдлаар тухайн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэрэгд бүрэн хэмжээгээр шалгах хүлэж авах бөгөөд хүлээн авах комисс тогтоосон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хурдаас, хуулийн тэмдэглэл, Хавсралт №11-т заасан маягийн дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэрэгд үйлдэх санхүүжилтийн баримт бичгийг иж бүрдэл хавсаргана." гэсэн заалттай нийцэхгүй байна.

011041265

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гэрээлэхгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.8-4.2.1.9, 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Техникийн тодорхойлолтыг хууль, тогтоомжид нийцүүлэн боловруулж, тендерийг бодитоор үнэлэх, техникийн тодорхойлолтод нийцэхгүй автомашин хүлээн авахгүй байх, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ
АУДИТОР  Я.ЗОРИГ


ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 05 сарын 27 өдөр
Дугуйр 389/116041263-2021/77-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх болон хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу "Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд хяналт шалгалтыг хийгээгүй байгаа бөгөөд сүүлийн 3 жилд хийсэн манай аудитаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь "өөсний эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн аудитын тухай хуулийн 20.3 дахь "Шалгаадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүнийг үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5.2.4 дахь "төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүнийг үр ашгийг байдлаар хяналт тавих" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гэрээлэхгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахад өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлэхгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Дээрх хууль, журмыг хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

011041263

2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудад тавих дотоод хяналтыг цаг хугацаанд нь хийж, үр ашгийг тооцож, үнэлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ
АХЛАХ АУДИТОР  Б.ДЭЛГЭРМАА




**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

Баян-Өлгий / 05 сарын 09 өдөр
Тугаар: 508 / 11.10.10 / 304 - 304 / 75 - 018 - 18
Холбоонох хэл:

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх болон хуулийн 9 дүгээр зүйлийн заасны дагуу "Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнөг оруулалтын төлөвлөгөөний хэрэгжигч, үр дүн, үр ашгийг гүйцэтгэлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрээ. Үүнд:

Үнэлгээний хороодын 2020 онд зохион байгуулсан зарим худалдан авах ажиллагаагаар тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй орлогчийг шалгаруулсан байна. Үүнд:

- "Нисэх онгоцны будалд барих" /Баяндун, Халхгол сум/ ажлын тендэрт оролцсон Стандарт рэзидэнд контраст ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТӨӨЗ-ын 5.3.(а), 14.1(к) "4-д заасан шаардлагыг хангаагүй байхад.
- "Сумын Засаг даргын Тамгын газрын нам даргалтын зуухны засвар" /Булган сум/-ын ажлын тендэрт оролцсон Энтрүүд ХХК-ийн санал ирүүлсэн ажлын төсвийн захиалгачийн албаны зардал, зурга төсөв зохиогчийн хяналтын зардал, магадлангүй ажлын зардлыг дүн нь энэ ажлын батлагдсан төсөвт тусгасан тухайн зардлын дүнгээс уруулж байхад;
- "Мал хуулиглах гэмт хэргийг тэмдэгт тасарт автомашин" нийлүүлэх тендэрт оролцсон Дорнын этгүүн ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТӨӨЗ-ын 1.1.3-д заасан шаардлагыг хангаагүй байхад;
- "Сумдын цагдаагийн тасаг, хэсгийн байрны засвар, тохижилт"-ын ажлын тендэрт оролцсон Дорнын их дөл ХХК-ийн тендерийн материалд барилгын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ байхгүй, ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай инженер техникийн ажилтны мэдээллийг иргүүлээгүй байхад;
- "Жуулчадад зориулсан мэдээллийн төв" /Мүүлунгоот сум/-ийн ажлын тендэрт оролцсон Донж Өргөө ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТӨӨЗ-ын 1.1.4-д заасан шаардлагыг хангаагүй байхад;
- "Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үндэслэлийн бааз"-ын ажлын тендэрт оролцсон Дорнод хийц ХХК-ийн тендерийн материалд барилгын

1. Турассар шалгах бол техникийн хэрэгслийн түрээсийн гэрээг ирүүлэх бөгөөд түрээсийн гэрээг тухайн төсөлд зориулсан байгуулсан байна.
2. Тендерийн болон нь өөр барилгыг оруулалтын аклыг гүйцэтгэх байгаа бол энэ тухай мэдээллийг ирүүлэх шаардлагатай бөгөөд зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд "... машин механизмудыг санал болгос ба дансанд тооцогдоход татлахаа үүсгэлд болно." гэж Захиргаа тухайн 2015 оны 326 дугаар тушаалын дүрэн барилгын засварын аманд ашигласаа Монгол Улсын гаруй үүсдэгт бараа, материалын жогсаат; хэмжээг үүсгэлтэй дагуу гаргах үүрэгт.
3. Тухайн байгууллагын тодорхойлолт... Сүлжийн 2 жил гүйцэтгэсэн жилийн төсвийн ажлын гэрээ, хэрэгжлээг өрсө хомсоон олгох хавсаргана.
Түрээсийн гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулсан байгуулсан байх... бусад асуудлыг тодорой тусгаан байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Б.БОЛОРТУЛ
С.ЭНХБААТАР

2

011041269

